



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/698

Ховд


Зарим аж ахуйн нэгжүүдийн үйл
ажиллагааг түр зогсоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", "ж", "л", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн, Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, Ховд аймгийн Онцгой комиссын дэргэдэх шуурхай штабын 2020 оны 11 дугаар сарын 12-ны өдрийн 02 дугаар шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотод Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Баруун бүсийн төв зах, Их буян зах, Эвийн хүч худалдааны төв болон бусад худалдаа үйлчилгээний төвүүдэд хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулахаас бусад төрлийн бараа материал худалдан борлуулдаг үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 10.00 цагаас 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 08.00 цаг хүртэл хугацаагаар түр зогсоосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээллэн сурталчилж ажиллахыг сумдын Засаг дарга нар, Цагдаагийн газар /Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ДҮГЭРЖАВ



Zax A/698 Ch
02 3134